

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Гепатитын эмчилгээ

Хэрэв та архаг гепатит В-тэй бол элэгний гэмтэл хэзээ ч үүсч магадгүй байдаг учраас элгээ хянаж байхын тулд эмчдээ тогтмол үзүүлж байх шаардлагатай.

Элэгний В вирусийг хянаж, зохицуулж байх боломжтой эмүүд байдаг. Эдгээр нь таны элэгний гэмтэл болон элэгний хорт хавдраар өвчлөх эрсдлийг бууруулдаг. Эм уух хэрэгтэй эсэхийг эмч танд хэлж өгнө.

Гепатитын эсрэг вакцинжуулалт


Вакцинжуулалт нь гепатит В-ээс хамгаалах хамгийн сайн арга бөгөөд хэрэв та В гепатитын эсрэг вакцин хийлгэсэн бол уг вирусар халдварлахгүй.


Австралид нярай, бага насны хүүхэд, өсвөр насныхан, түүнчлэн В гепатитын халдвартай хүний гэр бүл, ойр дотны хүмүүст элэгний В вирусын эсрэг вакциныг үнэгүй хийж өгдөг.

Гепатит В вирусийн эсрэг вакцинжуулалтын талаар эмчээсээ асуугаарай.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ:

Олон үндэстний ХДХВ болон
Гепатитын үйлчилгээ
Мэдээлэл [Монгол хэл]


 www.mhahs.org.au


 info@mhahs.org.au


 TheMHAHS

Гепати NSW

Гепатитын тусламжийн утас


 www.hepb.org.au


 Сидней: 02 9332 1599

 NSW мужийн орон нутгаас: 1800 803 990

Гепатит Австрали

Үндэсний Мэдээллийн шугам


 www.hepatitisaustralia.com

 1300 437 222

Translating and Interpreting Service (TIS)

- Орчуулгын үйлчилгээг утсаар

Монгол орчуулагчтай ярих

 131 450

www.mhahs.org.au/index.php/en/hepatitis/hepatitis-b-testing

2025


ГЕПАТИТ В

ТА ГЕПАТИТ

В-ТЭЙ ЮУ?

ШИНЖИЛГЭЭ ӨГ.

МЭДЭЖ АВ.



ГЕПАТИТ В

ШИНЖИЛГЭЭ
ӨГӨӨРЭЙ

ГЕПАТИТ В ГЭЖ ЮУ ВЭ?

Гепатит В нь элэгний В вирусээр үүсгэгддэг элэгний халдвар бөгөөд Гепатит гэдэг үг нь элэгний үрэвсэл гэсэн утгатай.

Элэг үрэвссэн, болон гэмтсэн үед хэвийн ажиллахгүй байх магадлалтай ба энэ нь таны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болно.

Гепатит нь цочмог (богино хугацааны) эсвэл архаг (урт хугацааны) байж болно.

Архаг гепатит В нь халдвар 6 сараас дээш хугацаагаар үргэлжлэх үед үүсдэг. Энэ нь цаашлаад элэгний хатуурал (цирроз), болон элэгний хорт хавдар үүсгэдэг.

Шинж тэмдэг илрэх хүртэл хэдэн жил ч байж болдог учраас Архаг В гепатиттай ихэнх хүмүүс гепатит В-тэй гэдгээ мэддэггүй.

Эрүүл элэг



Гэмтсэн элэг




ТА ГЕПАТИТ В-ТЭЙ ЮУ?

Манай нийгэмд гепатит В элбэг байна.

Австралид амьдарч буй гепатит В-ийн архаг халдвартай хүмүүсийн дийлэнх нь В вируст гепатит их тархсан орнуудад төрсөн байдаг.

Гепатит В дэлхийд



Гепатит В-н халдвар авах уеийн нас бага байх тусмаа насанд хурсэн хойноо архаг В гепатитаар өвчлөх эрсдэл өндөр байдаг. Хамгийн түгээмэл тархдаг замууд нь:

- Төрөх үед эхээс хүүхдэд.
- Бага насанд шарх, эсвэл зүсэлт зэргээр дамжин хүнээс хүнд.

Гепатит В-ийн халдвар авсан нярайн 90% нь архаг В гепатитаар өвддөг.

ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ

Архаг гепатит В-тэй эсэхээ мэдэх цорын ганц арга бол гепатит В-ийн цусны шинжилгээ өгөх юм. Энэ нь хурдан бөгөөд хялбар арга.

Дараах тохиолдлуудад гепатит В-ийн шинжилгээ өгье гэж эмчдээ хэлээрэй:

- Гепатит В-н халдвар түгээмэл байдаг улсад төрсөн эсвэл амьдарч байсан.
- Гэр бүлийн гишүүн нь гепатит В, элэгний өвчин, эсвэл элэгний хорт хавдартай.
- Архаг В гепатиттай хүнтэй хамт амьдардаг.
- Хамгаалалтгүй бэлгийн хавьталд (бэлгэвчгүй бэлгийн харьцаанд) орсон.
- Тоног төхөөрөмжөө зохих ёсоор ариутгадаггүй (цэвэрлэдэггүй) гадаадын оронд эмнэлгийн болон шүдний мэс ажилбар хийлгэсэн бол.
- Шивээс хийлгэх, цоолох, эсвэл зүү тавих зэрэг цус гардаг соёлын зан үйлд оролцсон бол.
- Хилийн чанадад эсвэл 1990 оноос өмнө Австралид цус сэлбүүлсэн бол.

